

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСЭЭС 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022.06.13

Алтай хот

Д/д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан	Биелэлт
НЭГ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын чиглэлээр:				
1.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах.	Жилдээ	Хэлтсийн дарга Хяналтын байцаагч	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах ажлын хүрээнд хэлтсийн үйлчилгээний танхимд 22 мэдээлэл байршуулж, албан хаагчид болон ард иргэдэд сурталчлах ажлыг зохион байгууллаа.
2.	Цахим Хөгжлийн багц хуулиудын хэрэгжилтийг хангах, хуулиудыг сурталчлах	Жилдээ	Хэлтсийн дарга Иргэний бүртгэлийн тасгийн дарга	2022.05.01-ны өдрөөс Цахим Хөгжлийн багц хуулиуд хэрэгжиж иргэдэд тоон гарын үсэг олгох ажил эхэлсэнтэй холбогдуулан 2000 иргэнд тоон гарын үсэг олгож хуулиудыг сурталчлах ажлын хүрээнд “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг 2022.05.02-ны өдөр зохион явууллаа.
3.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангах, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн	Жилдээ	Хэлтсийн дарга	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн үйлчилгээний нээлттэй

	албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх, нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хариуцлага хүлээлгэх			байдлыг хангах, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хэлтсийн зүгээс тогтмол хяналт тавьж, алба хаагчдад үүрэг, чиглэл хүргэн ажиллаж байна.Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн албан хаагчдад холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй болно.
--	---	--	--	--

ХОЁР. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг албан хаагчдад сурталчлах, сургалт зохион байгуулах ажлын чиглэлээр

1.	Үйлчилгээний танхим болон нэг цэгийн үйлчилгээний байруудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга, санамж материалыг байршуулах, тараах, байгууллагын веб хуудсанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл байршуулах.	Жилдээ	Хяналтын байцаагч Мэдээлэл технологийн ажилтан	Үйлчилгээний танхим болон “Нэг цонхны үйлчилгээ”-ний байрууд болон веб хуудсанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 12 ш анхааруулга, санамж материалыг байршуулсан.
2.	Шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас болон үйлчилгээний танхимын тогтмол байршуулж, албан хаагч, иргэдэд мэдээллийг хүргэж сурталчлах	Жилдээ	Хэлтсийн дарга Мэдээлэл технологийн ажилтан	“Мэдээллийн аюулгүй байдал, кибер орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт хичээл болон Терроризмтой тэмцэх тухай хууль, шинээр батлагдан гарсан зөрчлийн тухай хууль тогтоомжуудыг веб хуудсанд байршуулж хамт олныг мэдээ мэдээллээр хангалаа.
3.	Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын дүн, арга хэмжээний талаар болон авлигын эсрэг хууль тогтоомжийг	Хагас жил тутамд	Хэлтсийн дарга Аймгийн Шүүх,Прокурор,	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” болон “Ашиг сонирхолын зөрчлөөс

	сурталчлах зорилгоор Хуулийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах		Цагдаагийн газар	урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр “Авилга ашиг сонирхол, терроризм, кибер орчны гэмт хэрэг” сэдвээр аймгийн Тагнуулын хэлтсээ сургалт хийж хэлтсийн 22 албан хаагч хамрагдав. Мөн аймгийн Шүүхийн шүүгч ЦҮйтүмэнтэй хамтран 2022 оны 5 сарын 10-нд Авлигын талаарх сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулж сумдын 18 бүртгэгч, аймгийн төвийн 10 албан хаагчийг бүрэн хамруулсан. “Авлигаас урьдчилан сэргийлэх” талаар аймгийн Шүүх, Прокурор, Цагдаагийн газартай тогтмол хамтын ажиллагаатай үйл ажиллагаа явуулж байна..
4.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Хуулийн байгууллагуудтай хамтран Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн тухай хуультай холбоотой асуудлаар албан хаагчдад зайны болон танхимын сургалт хийх.	2,3 дугаар улиралд	Хэлтсийн дарга Аймгийн Шүүх,Прокурор, Цагдаагийн газар	Тус хэлтсийн Хяналтын Улсын байцаагч Д.Оюунчимэг Зөрчлийн тухай хуулиар албан хаагчдад сургалт хийсэн. 2022.05.24-ний өдөр аймгийн Цагдаагийн газартай хамтран Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 цагийн сургалтыг цагдаагийн хурандаа Н.Эрдэнэ-Очир хийв.
ГУРАВ. Улсын бүртгэлийн нэгдсэн сангийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр				
1.	Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийн сангийн аюулгүй байдал, нууцлалт, хамгаалалтыг хариуцан ажиллаж байгаа албан	1 дүгээр улиралд	Хэлтсийн дарга	Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд харьцаж ажиллаж байгаа албан хаагчдад мэдээллийн сангийн

	хаагчдын ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, үүрэгжүүлэх			аюулгүй ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгч ажил үүргийн хуваарийг тодорхой болгож үүрэгжүүлсэн. Гэмт хэргээс сэргийлэх талаар 6 санамж материалыг байгууллагын цахим хаяг болон мэдээллийн самбарт тогтмол байршуулан ажиллаж байна.
2.	Улсын бүртгэлийн мэдээллийн сантай харьцаж байгаа албан хаагчдад сургалт явуулж нууцын баталгааг шинэчлэх.	1 дүгээр улиралд	Хэлтсийн дарга Мэдээлэл технологийн ажилтан Тагнуулын хэлтэс	Тус хэлтэс нь 2022 оны 1 дүгээр сард нийт албан хаагчдаас нууцын баталгааг шинэчлэн гаргуулж авсан.
ДӨРӨВ. Сахилга харицлага, дэг журмыг сайжруулах чиглэлээр:				
1.	Албан хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгаж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.	Жилдээ	Хэлтсийн дарга	Өнөөдрийн байдлаар албан хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл ирээгүй.
2.	Албан хаагчдын цаг ашиглалт, хөдөлмөрийн дотоод журам болон үйл ажиллагаатай холбогдуулан тогтоосон журмыг сахиж ажиллахад хяналт тавьж, зөрчил дутагдал гаргасан албан хаагчдад хариуцлага тооцох.	Жилдээ	Хэлтсийн дарга	Өдөр тутмын ажлын байрны цаг ашиглалт, ажлын үр дүнгийн талаар хэлтсийн дарга үүрэг даалгаврын дэвтэр хөтлөн баталгаажуулж 14 хоног тутам хамт олны хурлаар хэлэлцэж хэвшсэн. Мөн сумдын бүртгэгч нартай сард 2 удаа цахим хурлыг хийж үүрэг даалгавар чиглэл өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.	Байгууллагын орчинд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор камер, дохиолол болон галын утаа, хөдөлгөөн мэдрэгчийг байршуулах	Жилдээ	Хэлтсийн дарга Ахлах нягтлан бодогч	Байгууллагын орчинд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тус хэлтсийн үйлчилгээний танхимд галын утаа мэдрэгч тогтмол ажиллагаатай байдаг бөгөөд хэлтсийн үйлчилгээний танхимын дотор, гадна талд 4 ш камер байршуулан тогтмол хяналт тавьж байна.
4.	Нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд ажиллах шуурхай баг, хариуцлагатай жижүүрийн хуваарийг гаргаж, хяналт тавьж ажиллах	Тухай бүр	Хэлтсийн дарга	Нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд ажиллах эргүүл жижүүрийн хуваарийг тогтмол гарган ажиллахаас гадна хэлтсийн онцгой байдлын төлөвлөгөөнд томилогдсон шуурхай баг хяналт тавьж ажиллаж байна.

ХЯНАСАН:

ДАРГА

Г.ЧҮЛТЭМЖАМЦ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ, НЯРАВ

Э.ЦЭРЭНДУЛАМ